



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2021 оны 11 сарын 25-ны  
өдрийг 5560 дугаарт бүртгээ.

## СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/153

Улаанбаатар хот

### Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Стандарт, хэмжил зүйн газрын даргын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт, шалгалт хийх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн хянуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зохих арга хэмжээ авч ажиллахыг Хэмжил зүйн бодлогын газар (Д.Нарангэрэл)-т, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Ууганбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Хэмжил зүйн зөвлөлийн 1999 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт явуулах дүрэм”-ийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Б.БИЛГҮҮН

Бүртгэлийн дугаар 93

**ХУУЛБАР ҮНЭН**  
Монгол улсын Засгийн газрын  
Төжирүүлэгч агентлаг  
СТАНДАРТ,  
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР  
Архивын эрхлэгч  
2021 оны 11 сарын 08 ний өдөр

028021-40



Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд  
Хэмжил зүйн хяналт, шалгалт хийх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хэмжил зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасныг үндэслэн төрөл бүрийн сав, баглаа боодолтойгоор үйлдвэрлэх, импортлох, худалдах бүтээгдэхүүний (цаашид "савласан бүтээгдэхүүн" гэх) тоон хэмжээнд болон сав баглаа, боодлын хаяг, шошгонд тавих хэмжил зүйн шаардлагыг тогтоох, хэмжил зүйн хяналт шалгалт хийх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Төрөл бүрийн сав, баглаа боодолтой бүтээгдэхүүнийг савлан худалдах үед тавих бүтээгдэхүүний тоон хэмжээнд хийх хэмжил зүйн хяналт шалгалтыг мэргэжлийн хяналтын байгууллагын хэмжил зүйн хяналтын улсын байцаагч (цаашид "улсын байцаагч" гэх) гүйцэтгэнэ.

1.3 Үйлдвэрлэгч, аж ахуйн нэгж байгууллага болон түүний хэмжил зүйн ажилтнууд савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хийх дотоод хяналт шалгалтыг энэхүү журмыг мөрдлөг болгон хэрэгжүүлж болно.


1.4 Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хийх хяналт, шалгалтад холбогдох хэмжил зүйн ба мэргэжлийн байгууллагууд болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг татан оролцуулж болно.

Хоёр. Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд болон  
түүний сав баглаа боодлын хаяг, шошгонд  
тавих хэмжил зүйн шаардлага

2.1. Худалдахад бэлэн болгосон сав, баглаа боодолтой бүтээгдэхүүний тоон хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1 Савласан бүтээгдэхүүн тус бүрийн хэвийн тоон хэмжээ (M) цэвэр тоон хэмжээний (m) утгын зөрүү нь тухайн бүтээгдэхүүний норматив баримт бичиг, техникийн нөхцөл, стандартад заасан тоон хэмжээний хэвийн утгын зөвшөөрөх хэлбэлзэл (T)-ээс ихгүй байна. Хэрэв норматив баримт бичигт өөрөөр заагаагүй бол савласан бүтээгдэхүүний цэвэр тоон хэмжээний хэлбэлзэл (T) нь хэвийн тоон хэмжээний зөвшөөрөх хэлбэлзлээс их байвал уг сав, боодлыг тэнцэхгүйд тооцно. Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний зөвшөөрөх хэлбэлзлийн хязгаарыг энэ журмын нэгдүгээр хавсралтад зааснаар холбогдох стандартын дагуу тооцно. 93

2.1.2 Тухайн бүтээгдэхүүний баримт бичигт тоон хэмжээний зөвшөөрөх хэлбэлзэл (T) –ийн хязгаарыг заагаагүй тохиолдолд MNS OIML R 87 стандартад заасны дагуу сонгон авна.





2.1.3 Савласан тухайн бүтээгдэхүүний норматив баримт бичигт өөрөөр заагаагүй бол савласан цуврал бүтээгдэхүүний цэвэр тоон хэмжээний дундаж утга нь хэвийн тоон хэмжээний утгын зөвшөөрөгдөх хэлбэлзэл (Т)-ийн хязгаар дотор байна.

2.1.4 Шаардлагад тэнцэхгүй савласан бүтээгдэхүүний тоо (Ср) нь норматив баримт бичгээр тогтоосон түүвэр дэх тэнцэхгүй савласан бүтээгдэхүүний зөвшөөрөх тоо (С)-ноос илүүгүй байвал тухайн цуврал бүтээгдэхүүнийг тэнцсэн гэж үзнэ.

2.1.5 Хэмжил зүйн хяналт, шалгалтын үед савласан бүтээгдэхүүний сав, баглаа боодол тус бүрийн цэвэр тоон хэмжээ(м), тухайн бүтээгдэхүүний тоон хэмжээний (М) хэвийн утгын зөвшөөрөх хэлбэлзэл (Т)-ийн 1/5-ээс ихгүй алдаатай хэмжинэ.

*Тайлбар 1: Онцгой тохиолдолд хэмжлийн алдаа нь бүтээгдэхүүний тоон хэмжээний хэвийн утгын зөвшөөрөх хэлбэлзэл (Т)-ийн 1/3-ээс ихгүй байж болох ба хэмжлийн алдааг ихэсгэсэн үндэслэлийг шалгалтын үр дүнгийн тайланд тэмдэглэнэ.*

## 2.2 Бүтээгдэхүүний сав баглаа боодлын хаяг, шошгонд тавих хэмжил зүйн шаардлага

2.2.1 Савласан бүтээгдэхүүний сав, баглаа, боодлын хаяг, шошго нь MNS OIML R79 “Савласан бүтээгдэхүүний хаяг шошгод тавих шаардлага” стандартад заасан шаардлагад нийцсэн байна.

2.2.2 Бүтээгдэхүүний сав баглаа боодлын хаяг шошгон дээрх мэдээлэл нь хэрэглэгчдийг төөрөлдүүлэхээргүй, үнэн зөв байна.

2.2.3 Сав баглаа боодлын хаяг шошгонд тухайн бүтээгдэхүүний нэр, үйлдвэрлэсэн орон, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, бүтээгдэхүүний орц найрлага, үйлдвэрлэсэн болон хадгалах эсвэл хэрэглэж дуусах хугацаа, тээвэрлэх, хадгалах, хэрэглэх заавар, цэвэр болон бохир жин, стандартын дугаар зэргийг заавал бичсэн байна. Шаардлагатай тохиолдолд сав, баглаа боодлын шинж чанарыг тодорхойлсон байна.


2.2.4 Сав баглаа боодлын хаяг, шошгон дээр тухайн бүтээгдэхүүний тоо хэмжээг хэмжлийн нэгжийн “SI” Олон Улсын системийн нэгжээр бичиж тэмдэглэсэн байна.

*Тайлбар 2: Импортоор нийлүүлж байгаа бүтээгдэхүүн нь үйлдвэрлэгч улсын дотоод дүрэм журмын дагуу тэмдэглэгдсэн бол Монгол хэл рүү хөрвүүлэн нэмэлт наалт хийж болно.*

### Гурав. Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хийх хэмжил зүйн хяналт, шалгалтын үйл ажиллагаа

3.1 Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хийх хэмжил зүйн хяналт, шалгалт нь дараах хэлбэртэй байна:

- 3.1.1 Төлөвлөгөөт хяналт шалгалт;
- 3.1.2 Төлөвлөгөөт бус хяналт шалгалт;
- 3.1.3 Урьдчилан сэргийлэх шалгалт;
- 3.1.4 Гүйцэтгэлийн хяналт шалгалт.





3.2 Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хийх хэмжил зүйн хяналт, шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу хийх бөгөөд хэмжил зүйн хяналт, шалгалтад хамрагдах үйлдвэрлэгч, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад хяналт, шалгалтын удирдамж, зорилго, хугацааг танилцуулсан байна.

3.3 Хэмжил зүйн хяналт, шалгалтад хамрагдах савласан бүтээгдэхүүний нэрсийг тодорхойлон гаргана.

3.4 Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд тавигдах шаардлагыг тогтоосон холбогдох стандарт, норматив техникийн баримт бичигтэй танилцана.

3.5 Савласан бүтээгдэхүүний сав, баглаа, боодлын хаяг, шошго нь энэ журмын 2.2.1- 2.2.4-т заасан шаардлагууд хангаж буйг шалгана.

3.6 Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хийх хэмжил зүйн хяналт, шалгалтыг MNS OIML R 87 “Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээ” стандартын дагуу хийж гүйцэтгэх бөгөөд үйлдвэрлэлийн технологийн процессод үзүүлэх нөлөө, зардлыг аль болохоор бага байлгах, шалгалтад хамрагдсан савласан бүтээгдэхүүнийг гэмтээхгүй байхаар зохион байгуулна. Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хяналт шалгалт хийхэд ашиглах ажлын эталон жингийн хэмжил зүйн үзүүлэлтийг энэхүү журмын тавдугаар хавсралтад заасан жишгээр ашиглана.

*Тайлбар 2: Хэрэв сав, баглаа боодлын тоон хэмжээ тодорхой буюу түүнийг шалгалтын явцад тодорхойлж болох бол түүнд савласан бүтээгдэхүүний цэвэр тоон хэмжээний утгыг сав, баглаа боодлыг онгойлгож гэмтээлгүйгээр шууд бус аргаар тодорхойлно.*

*Тайлбар 3: Түүвэр сонгох, цэвэр тоон хэмжээг хэмжих, хэмжлийн үр дүнг боловсруулах, дүгнэлт гаргах үйл ажиллагаа нь энэхүү журамд заасан шаардлагатай нийцэж байгаа тохиолдолд тухайн бүтээгдэхүүний стандарт, норматив техникийн баримт бичгийн дагуу хийж болно.*

3.7 Хэмжил зүйн хяналт, шалгалтын үед савласан бүтээгдэхүүний түүврийг, савлалтын дамжлага болон савласны дараа, түүнчлэн бэлэн бүтээгдэхүүний агуулахаас сонгон авч болно. Цувралын хэмжээ нь үйлдвэрлэгчийн савлах үйл ажиллагааны тухай бүрэн, зөв мэдээлэл өгөхөд хүрэлцэхүйц байвал зохино.


*Тайлбар 4: Хэрэв нэг цувралын хэмжээ нь хяналт шалгалтын үр дүнг үнэн бодитой гаргахад хүрэлцэхгүй гэж үзвэл ижил төрлийн хэд хэдэн цувралыг нэгтгэж нэг цуврал болгож болно.*

3.8 Савласан бүтээгдэхүүний цувралаас түүвэрлэн авахдаа, нийт цуврал бүтээгдэхүүний аль ч нэгж адил магадлалтай сонгогдох аргыг хэрэглэнэ.

3.9 Түүврийн хэмжээг дараах байдлаар тооцож тодорхойлно:

3.9.1 Савласан бүтээгдэхүүний сав, боодол бүр нь өөр өөр тоон хэмжээний хэвийн утгатай бол шалгалтад 10-аас доошгүй сав, боодлыг сонгон авна. 93

3.9.2 150-иас доош нэгж агуулсан савласан бүтээгдэхүүний цувралаас авах түүврийн хэмжээ нь нийт бүтээгдэхүүний 20 хувиас багагүй байна.





3.9.3 150-иас дээш нэгж агуулсан савласан бүтээгдэхүүний цувралаас авах түүврийн хэмжээ (n)-г дараах томъёогоор тодорхойлж авна:

$$n = 30 + 0.0125 N \quad (1)$$

Энд:

N - савлагааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц цувралын хэмжээ.

3.10 Сав, баглаа боодлыг нь эвдэхгүйгээр доторх бүтээгдэхүүний тоон хэмжээг шалгах боломжгүй тохиолдолд хоёр буюу олон шатлалтай шалгалт явуулах зэргээр түүврийн хэмжээг багасгаж болно.

*Тайлбар 5: Түүврийн хэмжээг үндэслэлгүй багасгах нь шалгалтын үр дүнгийн үнэн зөв байдал буурч стандартын шаардлага хангахгүйд хүргэдэг.*

3.11 Савласан бүтээгдэхүүнээс авсан түүврийн сав, баглаа боодол тус бүрийн цэвэр тоон хэмжээ (m)-г хэмжинэ. Хэмжлийн үр дүнг тайланд тусгана.

3.12 Тухайн бүтээгдэхүүний норматив баримт бичигт хэмжлийн үр дүнг боловсруулах аргачлал тусгагдаагүй бол савласан цуврал бүтээгдэхүүний тоон хэмжээний дундаж утгын хэмжлийн үр дүнгийн боловсруулалтыг энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу гүйцэтгэж, түүнээс гарах дүгнэлтийг шалгалтын тайланд тэмдэглэнэ.

3.13 Шалгалтаар тэнцээгүй савласан бүтээгдэхүүнийг тусгай таних тэмдэг (P)-ээр тэмдэглэж, тэнцээгүй бүтээгдэхүүний тоо (Cp) нь тухайн бүтээгдэхүүний норматив баримт бичигт заасан тэнцээгүй бүтээгдэхүүний зөвшөөрөх тоо (C)-ноос их байвал тухайн цуврал бүтээгдэхүүнийг тэнцэхгүй цуврал бүтээгдэхүүн гэж тооцон илэрсэн зөрчлийг "акт", "заавал биелүүлэх шаардлага"-д заан уг зөрчлийг арилгах хүртэл худалдан борлуулахгүй.

### Дөрөв. Хэмжил зүйн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт

4.1 Савласан бүтээгдэхүүнд хийсэн хэмжил зүйн шалгалтын үр дүнг энэхүү журмын гуравдугаар хавсралтад заасны дагуу хэмжил зүйн улсын байцаагч нэгтгэн, дүгнэлт гаргана.


4.2 Төрөл бүрийн сав, баглаа боодолтой бүтээгдэхүүний тоон хэмжээг савлах ба худалдах үед шалгасан үр дүн, илэрсэн зөрчлийг шалгалтын тайланд бичиж тэмдэглэнэ.

4.3 Хяналт шалгалтад оролцсон холбогдох байгууллагын төлөөлөл шалгалтын тайлан, дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулах ба түүнд нэмэлт өөрчлөлт оруулахгүй.

4.4 Хяналт шалгалтад оролцсон холбогдох байгууллагын төлөөллийн санал зөрүүтэй гарсан тохиолдолд эцсийн шийдвэрийг ажлын хэсгийн ахлагч гаргана.

4.5 Шалгагдаж буй үйлдвэрлэгч, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл гарсан дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол өөрсдийн саналыг бичиж дүгнэлтэд хавсаргана.

4.6 Шалгалтын тайланг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад танилцуулах бөгөөд дүгнэлтийг эс зөвшөөрөх тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллага энэ тухай тайлбараа бичгээр өгөх эрхтэй.





4.7 Хэмжил зүйн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т заасны дагуу төрөл бүрийн сав, баглаа боодолтой бүтээгдэхүүний тоон хэмжээнд хийсэн хэмжил зүйн төрийн хяналт шалгалтын ажлын тайланг Хэмжил зүйн зөвлөлд жил бүрийн 12 дугаар сард багтаан танилцуулж, тайлагнана.

### Тав. Бусад

5.1 Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар өгөх ба биелэлтийг албан бичгээр авна.

5.2 Хэмжил зүйн хяналт, шалгалтын үр дүнд тухайн савласан бүтээгдэхүүн нь энэхүү журмыг зөрчсөн, хэрэглэгчийг хохироосон нь баримтаар тогтоогдсон бол хууль бусаар олсон орлогыг дараах томъёогоор тооцож акт үйлдэнэ.

$$O_{зб} = \Delta X_з \times Y_H \quad (2)$$

Үүнд:

$O_{зб}$ - тоон хэмжээний дутуугаас олсон зүй бус орлого, төг;

$\Delta$ - нэгж сав, баглаа боодлоос дутсан тоон хэмжээ;


$X_з$ -дутуу савлагаатай дүгнэлтэд хамрагдах ёстой гэж баримтаар нотлогдсон сав, баглаа боодлын нийт тоо, ширхэг;

$Y_H$  – бүтээгдэхүүний нэгж тоон хэмжээний (г, эсвэл мл) үнэ, төгрөг.

5.3 Хэрэв шалгалтын явцад бусад баримт материалыг тодруулан шалгахад илэрсэн зөрчил нь зөвхөн нэг удаагийн шинжтэй (бүтээгдэхүүнийг борлуулаагүй гэх мэт) хэрэглэгч, худалдан авагчийг хохироогоогүй бол цуврал бүтээгдэхүүнийг борлуулахыг зогсоож, зөрчлийг арилгуулах “Заавал биелүүлэх шаардлага” өгнө. Зөрчлийг арилгасаны дараа түүнийг худалдан борлуулахыг зөвшөөрнө.

5.4 Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----





Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт, шалгалт хийх журмын нэгдүгээр хавсралт

Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний зөвшөөрөх хэлбэлзлийн хязгаар

1-р хүснэгт

Тоон хэмжээний хэвийн утга М (г эсвэл мл)	Зөвшөөрөх зөрүү (Т)	
	М-ээс хувиар, %	г эсвэл мл
5-аас 50 хүртэл	9	-
50-иас 100 хүртэл	-	4.5
100-аас 200 хүртэл	4.5	-
200-аас 300 хүртэл	-	9
300-аас 500 хүртэл	3	-
500-аас 1000 хүртэл	-	15
1000-аас 10000 хүртэл	1.5	-


Тоон хэмжээний хэвийн утга М (кг буюу л)	Зөвшөөрөх зөрүү (Т)	
	М-ээс хувиар, %	г эсвэл мл
15-50	1.0	-
50-100	-	500
100-аас дээш	0.5	-

Т-ын утгыг М<1000 г (эсвэл мл)-т аравны нэг бутархайгаар, М>1000 г (эсвэл мл)-т бүхэл нэгжээр тус тус нарийвчилна.

2-р хүснэгт

Сав, баглаа боодолтой савласан бүтээгдэхүүний түүвэр дэх тэнцэхгүй сав, боодлын зөвшөөрөгдөх тоо, С

Цувралын хэмжээ, N	Шалгахаар авсан түүвэр дэх тэнцэхгүй сав, баглаа боодлын зөвшөөрөх тоо хэмжээ, С ширхэг
50	0
51-150	1
151-1000	2
1001-2000	3
2001-3500	4
3501-5000	5
5001-ээс дээш	N-ээс 0.1 хувиар





Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд  
хэмжил зүйн хяналт, шалгалт хийх  
журмын хоёрдугаар хавсралт

**Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд  
шалгалт хийсэн тухай тайлан**

Шалгалтыг \_\_\_\_\_  
(шалгалт хийсэн эрх бүхий байгууллагын нэр)

Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч  
\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_  
202.. оны ... дугаар ... сарын ... -ны өдөр хийв.

Шалгалтад \_\_\_\_\_  
(шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын нэр)  
\_\_\_\_\_  
(шалгалтад хамрагдсан савласан бүтээгдэхүүний нэр, цувралын хэмжээ)

Шалгалтын үр дүнд эвдэрсэн сав баглааны \_\_\_\_\_  
Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хэвийн утга М (г эсвэл мл) \_\_\_\_\_

Тоон хэмжээний хэвийн утгын зөвшөөрөгдөх хэлбэлзлийн утга Т(г эсвэл мл)\_  
(5-10) %

Түүвэр дэх сав, боодлын тоо хэмжээ n \_\_\_\_\_

Түүвэр дэх тэнцэхгүй сав, баглаа боодлын зөвшөөрөгдөх тоо С 1-3 \_\_\_\_\_

Сав, баглаа боодлын дундаж жин \_\_\_\_\_


Хяналтын хэмжилтийг \_\_\_\_\_

(хэмжих хэрэгслийн нэр, маяг, хэмжлийн хязгаар, үнэмлэхүй алдаа, хэмжилт  
хийсэн он сар өдөр)

Хэмжлийн үнэмлэхүй алдааг зөвшөөрөгдөх хэлбэлзэлд харьцуулсан харьцаа  $\delta/T$   
%, % -  $\delta/T > 1/5$  бол хэмжлийн алдааг ихсэх үндэслэлийг бичнэ.

1. Сав, баглаа боодол тус бүрдэх тоон хэмжээ (г, мл)

Сав, баглаа боодлын дэс дугаар				
--------------------------------	--	--	--	--





Бүтээгдэхүүний тоо хэмжээ (г, мл)							
-----------------------------------	--	--	--	--	--	--	--

2. Хэмжлийн үр дүнгийн боловсруулалт:

3. Шалгалтын үр дүнд гарсан дүгнэлт

- 3.1. \_\_\_\_\_
- 3.2. \_\_\_\_\_
- 3.3. \_\_\_\_\_

Шалгалтын ахлагч, улсын байцаагч:


\_\_\_\_\_ овог нэр \_\_\_\_\_ гарын үсэг

Шалгалтад оролцсон:

\_\_\_\_\_ (ажил, албан тушаал) \_\_\_\_\_ (гарын үсэг) \_\_\_\_\_ (овог нэр)

Шалгалтын тайлантай танилцсан аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага :

\_\_\_\_\_ (албан тушаал) \_\_\_\_\_ (гарын үсэг) \_\_\_\_\_ (овог нэр)





Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд  
хэмжил зүйн хяналт, шалгалт хийх  
журмын гуравдугаар хавсралт

..... –д хийсэн сав, баглаа боодолтой бүтээгдэхүүний  
тоон хэмжээний хяналт шалгалтын ажлын үр дүн

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)  
Бүтээгдэхүүний нэр \_\_\_\_\_

Түүврийн хэмжээ \_\_\_\_\_ ширхэг


Зөвшөөрөх хэлбэлзэл, Т \_\_\_\_\_ г, (эсвэл мл)

Цэвэр тоон хэмжээ \_\_\_\_\_ г, (эсвэл мл)

п	х	п	х	п	х	п	х	п	х
		26		51		76		101	
		27		52		77		102	
		28		53		78		103	
		29		54		79		104	
		30		55		80		105	
		31		56		81		106	
		32		57		82		107	
		33		58		83		108	
		34		59		84		109	
		35		60		85		110	
		36		61		86		111	
		37		62		87		112	
		38		63		88		113	
		39		64		89		114	
		40		65		90		115	
		41		66		91		116	
		42		67		92		117	
		43		68		93		118	
		44		69		94		119	
		45		70		95		120	
		46		71		96		121	
		47		72		97		122	
		48		73		98		123	
		49		74		99		124	
		50		75		100		125	

Σх- цувралын дундаж хэмжээ

Шалгалт хийсэн улсын байцаагч: .





Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт, шалгалт хийх журмын дөрөвдүгээр хавсралт

**5-р хүснэгт**

**Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хяналт шалгалт хийхэд ашиглах ажлын эталон жингийн хэмжил зүйн үзүүлэлт**

Сав, боодолтой бүтээгдэхүүний Бодит жин (г)	Жингийн хуваарийн хуваагдлын нэгж (г)
25 хүртэл	0.01
25-1000	0.1
1000-5000	1.0
5000-аас дээш	2.0

Тайлбар: Сав баглаа боодолтой бүтээгдэхүүний тоон хэмжээний хяналт шалгалт хийхэд ашиглах жингийн хуваарийн хуваагдлын нэгж нь уг сав, баглаа боодолтой бүтээгдэхүүний хамгийн бага зөвшөөрөх алдааны хэлбэлзэлтэй тэнцүү байхыг зөвшөөрнө.

----oOo----

